



СОЁМБО МЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

202 /2021/

2021.12.16

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

ЗХЖШ-ЫН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ХУРАЛ БОЛЛОО



ЗХЖШ-ын 2021 оны үйл ажиллагааны тайлангийн хурал өнөөдөр боллоо. Энэ үеэр Монгол Улсын төрийн дээд шагнал, тэргүүн зэргийн “Чингис хаан” одонгоор шагнагдсан, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойгоо өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүлсэн, зарим төрлийн цэргийн командлал, байгууллагуудыг шинээр байгуулж, үйл ажиллагаа нь жигдрүүлсэн, Зэвсэгт хүчний дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг батлуулсан, улс орны томоохон бүтээн байгуулалтад манлайлан оролцсон, энхийг дэмжих ажиллагаанд оролцох төрөл хэлбэрийг нэмэгдүүлэх алхмуудаа

амжилттай тодорхойлсон, анх удаа дотооддоо цэргийн зориулалттай зарим төрлийн техник хэрэгслийг туршиж, амжилттай үйлдвэрлэсэн зэрэг ажил үйлс, амжилт бүтээл өрнүүн өнгөрүүлж буй талаар ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, хурандаа С.Ганбямба танилцууллаа. Мөн ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, удирдах газрын 2021 оны гүйцэтгэлийн тайлангийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн талаараа ЗХЖШ-ын ХШҮГ-ын дарга хурандаа Ж.Өсөхбаяр илтгэж, оролцогчдоос тайлантай холбоотой санал бодлоо илэрхийлсэн юм.

/Үргэлжлэл нь II нүүрт /

Түүхэнд энэ өдөр

1945 он.

1945 оны Чөлөөлөх дайны туршлагыг нэгтгэн удирдах офицеруудад судлуулах тухай ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн жанжны тушаал гарчээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-19	-34

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,844.0	2,851.0
EUR	3,180.0	3,250.0
CNY	445.00	448.30
RUB	38.00	39.40
JPY	24.64	25.23
KRW	2.37	2.45

ЗУРХАЙ

2021.12.16 ПҮРЭВ ГАРАГ
/БИЛГИЙН ТООЛЛЫН 13/

ӨВЛИЙН ДУНД ЦАГААН ХУЛГАНА САРЫН ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ШАР НОХОЙ ӨДӨР

Үс засуулбал:
ЖАРГАЛ ИРНЭ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
08.36-17.00
Барилдлага:
Хүчин төгсөх
Шүтэн барилдлага:
Төрөхүй
Суудал:
Мод

Энэ өдөр бар, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын авшиг авах, шинэ гэр ба байр авах, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, хүүхэд үрчлэн авах, гэр, байшингийн суурь тавихад сайн. Эрдэнийг гадагш өгөх, нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийхэд муу.

Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одоосод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал ирнэ.

ДОРНЫН ЗУРХАЙ: Үс засуулбал ЖАРГАЛ ирнэ

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛСААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙДЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА



Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Бүгд Найрамдах Польш Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Кшиштоф Бойког хүлээн авч уулзлаа. Уулзалтаар хоёр улсын уламжлалт найрсаг харилцаа, батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагааг дүгнэн ярилцаж, цаашдын хамтын ажиллагааны чиг хандлагыг тодорхойлов.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Элчин сайд Кшиштоф Бойког хүрэлцэн ирж уулзаж байгаад сэтгэл өндөр байгаагаа илэрхийлээд хоёр орны Засгийн газрын түвшинд

байгуулсан Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны гэрээ, эрх зүйн баримт бичгийн хүрээнд хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэхийг зорьж байгаагаа илэрхийллээ.

Элчин сайд Кшиштоф Бойко хоёр орны харилцаа, батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлэх нь зүйтэй гэдэгт санал нэг байгаа бөгөөд БНПУ-ын цэргийн төрөл, мэргэжлийн сургуулиудад манай Зэвсэгт хүчний алба хаагчдыг суралцуулах боломжтойг илэрхийлээд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярыг БНПУ-ад албан ёсны айлчлал хийхийг уриалаа.

БХЯ-НЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУД СПОРТООР ӨРСӨЛДӨЖ БАЙНА



БХЯ-ны харьяа байгууллагууд жил бүр спортын төрлүүдээр өрсөлддөг уламжлалтай бөгөөд энэ удаагийн тэмцээн 16-17-ны өдрүүдэд сагс болон гар бөмбөг, ширээний теннис, дартс гэсэн 4 төрлөөр зохион байгуулагдаж байна. Цар тахлын улмаар 2 жил өнгөсөн бөгөөд энэ удаагийн тэмцээнийг БХЯ-ны харьяа

“Алдар” спорт хороо зохион байгуулж байгаа юм. БХЯ, ЗХЖШ, “Соёмбо” редакц, МЦМ, БХТА, ЦДБЭЧ, ЦТЭ зэрэг 19 байгууллагын 250 гаруй баг тамирчин оролцож байна.

Тус тэмцээний нээлтийн арга хэмжээнд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр оролцож баг тамирчдад спортын амжилт хүслээ



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН

2.264.125 /69.6%/

ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН

2,159,483 /66.4%/

ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН

833,158 26.0%

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

6745 +112

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

164

ЭДГЭРСЭН

6453

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 272,469,550

Эдгэрсэн

Нийт: 244,775,515

Нас барсан

Нийт: 5,345,391

цахим шууданд

ЗХЖШ-ЫН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ХУРАЛ БОЛЛОО

/Түрүүч нь I нүүрт/

Тайлангийн хуралд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар нар болон төрлийн цэргийн командлал, газар, хэлтсийн дарга нар оролцлоо. Түүнчлэн ЗХЖШ, төрлийн цэргийн командлалын бие бүрэлдэхүүн цахимаар оролцсон юм.



“ЗУСЛАНГИЙН НЭГ ӨДӨР”

Зэвсэгт хүчний 120 дугаар анги

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран энэ сарын 15-ны өдөр ангийн байрлалд “Зуслангийн нэг өдөр” арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд ГБХЗХ-ийн хэлтсээс 13 багш, ангийн бие бүрэлдэхүүнээс нийт 60 офицер, ахлагч, ажилтан албан хаагчид хамрагдсан юм.

Энэхүү үеэр “Од”, “Эрхэс”, “Мичид” гэсэн 3 бүлэгт хуваагдаж, “Гэр бүл”, “Хүүхэд”, “Залуучууд” танхимаар өртөөлөх хэлбэрээр хууль эрх зүйн мэдлэг олгох сургалтыг

явуулж, төгсгөлд нь соёл, олон нийтийн буухиа тэмцээн, уралдаан, урлагийн үзүүлбэрүүдийг зохион байгууллаа. Уг сургалт, соёлын арга хэмжээ нь анх удаагаа өргөн цар хүрээтэй явагдсанаараа онцлог байлаа. Цаашид анги, байгууллагын үйл ажиллагааг ардиргэд, энгийн байгууллагад сурталчлах ажлыг шат дараатайгаар төлөвлөн явуулахаар ажиллаж байна. “Ковид-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг мөрдлөг болгон ариутгал, халдваргүйжүүлэлтийн өндөр түвшинд дээрх арга хэмжээг зохион байгуулав.



ГАР БӨМБӨГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН-2021

ҮБХИС-ийн 2021 оны Гар бөмбөгийн аварга “Эмэгтэй баг” шалгаруулах тэмцээн тус сургуулийн “Спорт цогцолбор”-т энэ сарын 14, 15-ны өдрүүдэд амжилттай явагдаж дүнгээ гаргалаа.

Тэмцээнд 12 багийн 180 гаруй тамирчин оролцсоноос тэргүүн байрт Мэдээлэл сурталчилгаа, соёл, хүмүүжлийн тасгийн дарга, дэд хурандаа О.Ичинноров ахлагчтай “Чандмань одон” баг шалгарч 2021 оны гар бөмбөгийн аварга “Эмэгтэй баг”-аар шалгарсан бол, дэд байрыг Сургалтын хэлтсийн дарга, хурандаа Г.Болор ахлагчтай “Ирээдүй” баг, гутгаар байрыг Ахисан түвшний сургалтын албаны дарга, дэд хурандаа Д.Отгонцэцэг ахлагчтай “Бид чадна” багууд тус тус эзэллээ.

ҮБХИС-ийн 2021 оны гар бөмбөгийн аварга “Эмэгтэй баг” шалгаруулах, эмэгтэйчүүдэд нийтийн биеийн тамирыг сурталчлах, тэдний спортын ур чадварыг дээшлүүлэх, бие бялдрыг



хөгжүүлэх, хамт олонч уур амьсгалыг бүрдүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд оршиж байгаа юм. Сонирхуулахад тус тэмцээний нээлтэд зориулж Мэдээлэл сурталчилгаа, соёл, хүмүүжлийн тасгийн дарга, СТА, дэд хурандаа О.Ичинноров төрөлх сургуулийнхаа 100 жилийн ойд зориулан бүтээсэн шинэхан уран бүтээл болох СТА О.Эрдэнэцогийн хөгжим, О.Ичинноровын шүлэг “Чандмань одонт цэргийн их сургууль” дуугаараа

баг, тамирчдад амжилт хүсэж ая дуугаа өргөсөн нь олны хүндэтгэлийг хүлээсэн юм. Мөн нээлт, хаалтын ажиллагаанд тус сургуулийн Сургалт, цэргийн алба хариуцсан тэргүүн дэд захирал, хурандаа Ө.Эрдэнэ-Очир, Эрдэм шинжилгээ, нийгмийн түншлэл хариуцсан дэд захирал, шинжлэх ухааны доктор, профессор, хурандаа Б.Өлзийхуяг нар оролцож баг, тамирчдад баяр хүргэж, шагнал гардуулж, дараа дараагийн тэмцээнүүдэд амжилт хүссэн юм.



“ABU-ROBOSON 2021” ОЛОН УЛСЫН РОБОТЫН ТЭМЦЭЭНД ҮБХИС-ИЙН “АРАВТ” БАГ АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО



Ази-Номхон далайн орнуудын өргөн нэвтрүүлгийн холбооноос зохион байгуулдаг “ABU-ROBOSON 2021” олон улсын роботын 20 дахь удаагийн тэмцээн өнгөрөгч долоо хоногт цахим хэлбэрээр явагдлаа. Тэмцээнд тус холбооны гишүүн орнуудаас 12 улсын

21 багийн оюутнууд оролцож өөрсдийн зохион бүтээсэн роботуудаар сав руу сүм шидэх даалгавар гүйцэтгэж өрсөлдөв. Монгол Улсаас ҮБХИС-ийн “Аравт”, ШУТИС-ийн “Цахим-Алт” багууд эх орноо төлөөлөн оролцсон юм. Цахим тэмцээнд Монгол Улсаас оролцогч багууд

ҮБХИС-ийн “Алтан-Илд” спорт цогцолбороос зохион байгуулагч улс, бусад оролцогчтой “VooVmeet-ing” платформоор оролцож, Монголын Үндэсний телевиз шууд дамжуулалт хийв. Тэмцээнд оролцогч 21 баг 2 тойргоор тоглож, тус бүр 2 удаа “Сав руу сүм шидэх

даалгавар”-ыг гүйцэтгэн 80 оноо цуглуулан өрсөлдөж, дундаж оноогоор аварга багийг шалгаруулсан юм. ҮБХИС-ийн “Аравт” баг 1-р тойрогт 34 оноо, 2-р тойрогт 51 оноо цуглуулан нийт 42.5 оноо авч 18 дугаар байрт шалгарлаа.

Тус баг 3 дугаар сарын 15-наас энэ сарын 11-ний хооронд бэлтгэлээ базаасан бөгөөд робот техник зохион бүтээх, зүгшрүүлэх ажилд 9 багш, 28 сонсогч, оюутан, нийт 180 орчим ажилтан, алба хаагч оролцлоо. Нийт оюутнууд бэлтгэлийн

туршид механик хийцийн загварчлал, тооцоог “Solid-works-2021” программ ашиглан гүйцэтгэсэн юм. Ийнхүү ҮБХИС-ийн “Аравт” баг анх удаа олон улсын тэмцээнд амжилттай оролцож туршлага, сургамж хуримтлууллаа.



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
“Соёмбо” сонин
“Дуулга” студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)